

Sikaflex® Construction AP

1 Бүрэлдэхүүнт Полиуретан барилгын чигжээс

Бүтээгдэхүүний тодорхойлолт

Sikaflex® Construction AP нь 1 бүрэлдэхүүнт полиуретан барилгын уян чигжээс юм. Энэ бүтээгдэхүүнийг барилгын гадна болон дотор заслын аль алинд нь хэрэглэхэд тохиромжтой.

Хэрэглээ:

Sikaflex® Construction AP –г барилгын хөдөлгөөнтэй болон хөдөлгөөнгүй бүх төрлийн заагууд, жишээ нь, цонх, хаалга, фасад, өнгөлгөөний хавтан, бетон хоорондын зааг болон тоосго, мод, төмөр болон PVC хийцийн хэсгүүдийг хооронд нь барьцалдуулан чигжихэд хэрэглэнэ:

Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Хэрэглээ хялбар
- Элэгдэл болон цаг уурын нөлөөнд тэсвэртэй
- Зэвэрдэггүй
- Хөдөлгөөнт чадвар нь чигжээсийн өргөний дунджаас +/- 25%
- Бүх төрлийн гадаргуунд наалдан барьцалдах чадвартай
- Ажиллах чадвар онцгой сайн
- Хуулралтанд өндөр тэсвэртэй

Зөвшөөрөл / Стандарт

ISO 11600 (Type F Class 25HM/20LM)

Бүтээгдэхүүний мэдээллийн хуудас

Хэлбэр / Төлөв

Өнгө Бетонон саарал

Сав баглаа боодол Сосиск - 600 мл / 1 хайрцаганд - 20 сосиск



Хадгалалт

Хадгалах нөхцөл / хугацаа	Сав баглаа боодол онгойж, цоороогүй тохиолдолд үйлдвэрлэсэн өдрөөс 12 сарын хугацаанд хуурай сэрүүн нөхцөлд +10°C+20°C орчинд хадгална.
---------------------------	---

Техникийн мэдээлэл

Химийн найрлага	Агаарын чийгшилд бэхжих 1-бүрэлдэхүүнт полиуретан	
Нягт	~ 1.3 кг/л (бетонон саарал өнгөтэй)	(DIN 53479-д нийцсэн)
Бүрхүүл үүсэх хугацаа	~ 4 цаг (+23°C орчинд)	
Бэхжилтийн зэрэг	~ 3 мм / 24 цагт (+23°C орчинд)	
Хөдөлгөөний чадвар	+/- 25%	
Чигжээсийн хэмжээ	өргөний хэмжээ хамгийн багадаа =10 мм / өргөний хэмжээ хамгийн ихдээ = 35 мм	
Гулзайлт – Урсалт	0 мм , маш сайн	(DIN EN ISO 7390-д нийцсэн)
Хэрэглээний орчны Температур	-40°C-ээс +70°C-ийн орчинд	

Механик / Физик шинж чанар

Сунгалтын бат бэх	> 6 кг/см (+23°C орчинд)	(DIN 53515-д нийцсэн)
Хатуулагын чанар	28 хоногт ~ 30 (+23°C орчинд)	(DIN 53505-д нийцсэн)
Е-Модуль	(DIN EN ISO 8340-д нийцсэн) 100%-ийн суналтад ~0,5 N/mm (+23°C орчинд)	
Суналтын тасралт	~600% (+23°C орчинд)	(DIN 53504-д нийцсэн)
Суналтын дараа эргэн байрандаа орох уян хатан байдал	>70% (+23°C орчинд)	(DIN EN ISO 7389 В-д нийцсэн)

Системийн мэдээлэл

Хэрэглээний мэдээлэл

Зарцуулалт / Чигжээсний загвар	Заагны өргөн нь чигжих бүтээгдэхүүний хөдөлгөөнт чадварыг хангаж тооцоолон тусгасан байх шаардлагатай. Ерөнхийдөө заагны өргөн нь 10 мм-ээс их, 35 мм-ээс бага байдаг. Чигжээсний өргөн, гүн 2 хоорондоо ~ 2 : 1 харьцаатай байдаг. Заагны хэмжээг холбогдох стандарт дагуу Тооцоологч болон үндсэн гүйцэтгэгчид хэмжиж тогтоодог. Заагны өргөнийг тооцоололд чигжээс материалын үзүүлэлт, тухайн барилгад хэрэглэгдэх залгаа материалын шинж чанар, барилгад нөлөөлөх орчны нөлөө г.м зүйлүүдийн аргачлал, хэмжээгээр тодорхойлогддог.
--------------------------------	--

Зарцуулалтын ойролцоо хэмжээ:

Заагны өргөн	10 мм	15 мм	20 мм	25 мм	30 мм
Заагны гүн	8 мм	8 мм	10 мм	12 мм	15 мм
Заагны урт /600 мл сосиск	~ 7.5 м	~ 4.5 м	~ 2.5 м	~ 1.6 м	~ 1.3 м

Дэрлэх: Чигжээс материалын хөдөлгөөнт чанарыг хангахын тулд чигжээс цавууны ард полиуретан хөөсөнцөрөөр материалыг хийх хэрэгтэй.

Гадаргуун чанар Заагны гадаргуу тоос шороо, тос тосоол зэрэг урвалд орж болзошгүй чигжээс цавууны барьцалтад сөргөөр нөлөөлөх элдэв бохирдолгүй цэвэрхэн, бат бэх нэгэн жигд гадаргуу байх шаардлагатай. Ямар нэгэн сул эд, хэсэг байх ёсгүй.

Суурь түрхлэг Суурь түрхлэгийн тухай дэлгэрэнгүй зааварчилгааны дагуу. (Тусдаа зааварчилгаа баримт бий)

**Гүйцэтгэлийн нөхцөл байдал/
Хязгаарлалтууд**

Гүйцэтгэх гадаргуун Температур min. +5°C / max. +35°C

Орчны температур min. +5°C / max. +35°C

Гадаргуу дахь чийгшлийн хэмжээ Хуурай

Хэрэглэх заавар

Хэрэглэх аргачлал Sikaflex® Construction AP нь хэрэглэхэд бэлэн бүтээгдэхүүн юм.

Багаж Заагны гадаргууг бэлдсэний дараа заагны хөндий рүү дэр хөөсөнцөрөө хийгээд шаардлагатай бол суурь түрхлэг түрхэнэ. Сосиск бүхий чигжээсээ цавууны буунд хийгээд заагны эргэн тойрны хананд сайтар байрьцалдуулан Sikaflex® Construction AP-г зөөлөн шахна. Цавуугаа шахахдаа ямар нэгэн бөмбөлөг үүсгэж болохгүй.

Хурц ирмэг өнцөг бүхий газарт цавуугаа цэвэр жигд түрхэхийн тулд 2 ирмэгийн гадна талд цаасан наалт наагаад чигжээсээ түрхвэл бохирдолгүй цэвэрхэн түрхэж чадна. Дараа нь цавуугаа бэхжихээс өмнө цаасан наалтыг хуулж авна. Чигжээсний гадаргууг гөлгөр болгохын тулд чийгтэй тэгшлэгээр хөнгөн дарж өгч болно.

Багажыг цэвэрлэх Чигжээс цавууг хэрэглэсэний дараа бүх багаж, тоног төхөөрөмжүүдээ Sika® Remover 208 болон Sika Top Clean-T зэрэг цэвэрлэгч бодисуудаар цэвэрлэнэ. Хатсан болон бэхэжсэн бүтээгдэхүүнийг зөвхөн механик аргаар нь цэвэрлэх боломжтой.

Анхаарах зүйлс / Боломжууд Уян хатан чигжээсүүд дээр хатуу төлөвт болон уян хатан чанар багатай будагнуудыг түрхэж болохгүй.

Чигжээсэн дээр түрхэх нэмэлт түрхлэгүүдийг тохиромжтой эсэхийг урьдчилан туршиж үзэж шалгах хэрэгтэй.

Хэрэв тодорхой нэг түрхлэг/будгыг 6 сар болон түүнээс дээш хугацааны өмнө Sikaflex® Construction AP-тэй хавсарч хэрэглэж байсан тохиолдол байгаагүй нөхцөлд дараах туршилтыг Sikaflex® Construction AP дээр түрхэж үзэх хэрэгтэй:
- Түрхлэг/Будаг заасан хугацаандаа хатаж байгаа эсэх
- Түрхлэг/Будагны үе хатах явц хангалттай сайн буюу Sikaflex® Construction чигжээс дээр түрхэгдсэн хэсэг нь наран ил байгаа тохиолдолд тодорхой хугацааны дараа зөөлрөх ба/эсвэл ямар нэгэн

толбо үүссэн эсэх

- Түрхлэг/Будагны цавуулаг чанар нь Sikaflex® Construction-тай нийцэж байгаа эсэх.

Чигжээсний өнгө нь бусад химийн нэгдлүүдтэй урвалд орох, өндөр халуун болон хэт ягаан туяаны хэлбэлзлээс шалтгаалан өөрчлөгдөж болзошгүй. Гэхдээ өнгөний өөрчлөлт нь чигжээсний цавуулаг чанарт, элэгдэл г.м техникийн чанарт ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Байгалийн чулуунд хэрэглэх гэж байгаа тохиолдолд манай Техникийн Хэлтэсд урьдчилан хандаарай.

Sikaflex® Construction (AP)-г цонхонд, хар тосон гадаргуу бүхий материалууд, байгалийн гаралтай хаймар резинууд, тос ялгарч болзошгүй барилгын материалууд болон цавуунд химийн нөлөө үзүүлж болзошгүй уян налархайжуулагчид, уусгагч бүтээгдэхүүнүүдтэй хамт хэрэглэж болохгүй.

Sikaflex® Construction-ийг өмнө нь силикон төрлийн цавуу түрхэж байсан гадаргуун дээр нэмж хэрэглэх тохиолдолд хянуур байж манай Техникийн Хэлтэсээс зөвлөгөө аваарай

Sikaflex® Construction (AP)-г усан сангийн чигжээсэнд хэрэглэж болохгүй.

Усны даралттай болон ус агуулж буй бүтээцийн зааганд хэрэглэхэд тохиромжгүй.

Агааржуулалт сайтай орчинд хэрэглэхэд тохиромжтой.

Sikaflex® Construction (AP)-г спирт агуулсан уусгагч, шингэлэгч, цэвэрлэгээний бодис, хэвний тос тосоол зэрэг бодисуудтай харьцах орчинд хэрэглэж болохгүй. Дээр дурдсан бодисууд нь Sikaflex® Construction (AP) бүтээгдэхүүний бэхжилт явцад сөрөг нөлөө үзүүлэх боломжтой.

Эпокси резин будгийг Sikaflex® Construction дээр түрхэхдээ Sikaflex® Construction-ны бэхжилтийг бүрэн авсан буюу бүрэн хатсаны дараа түрхэх шаардлагатай. Учир нь эпокси будаг нь полиуретан чигжээс цавууны бэхжилтэнд саад болох нөлөөтэй.

Хэрэглэхдээ анхаарах зүйл Чигжээс бүтээгдэхүүн бүрэн хатаагүй орчинд бүтээгдэхүүнд ямарч хүнсний зүйл болон хүнсний сав суулгыг хүргэж болохгүй учир нь эмзэг мэдрэмтгий арьстай хүмүүст цочрол өгч болзошгүй. Тиймээс уг орчинд заавал хувийн хамгаалах хэрэгсэл буюу хувцас, бээлий, нүдний шил хэрэглэх нь зүйтэй. Мөн ажил дууссаны дараа биенд наалдсан чигжээс бүтээгдэхүүнийг халуун бүлээн ус, савантай усаар угаах, эсвэл резин цэвэрлэгч тос түрхэх нь зүйтэй. Уусгагч бүхий хүчтэй бодис хэрэглэхээс зайлхийх хэрэгтэй. Арьсаа хатаахын тулд даавуу бус харин нэг удаагийн цаасан алчуур хэрэглэх хэрэгтэй. Ажил гүйцэтгэж байгаа газар агааржуулалт сайтай байх ёстой. Нүд болон ам руу бүтээгдэхүүн орсон тохиолдолд цэвэр усаар сайтар зайлаад эмчид ханд.

Хууль эрх зүйн мэдээлэл

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыг өнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдэхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.

